



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/695

Арвайхээр сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Арвайхээр сумын орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” 25/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 1 нэгж талбарын газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг танхимаар явуулах бөгөөд дуудлага худалдааг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.

3. Дуудлага худалдаа явуулах зар мэдээг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг хүлээн авч дуудлага худалдааг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд) түүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

6225 11 1487

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дугаар
сарын 22-ны өдрийн 11/22 дугаар
захирамжийн хавсралт



АРВАЙХЭЭР СУМЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
БҮХИЙ ГАЗАРТ ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Төлөвлөж буй газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газар эзэмшүүлэх Зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /м2/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ (мян.төг)
1.	13-р баг Шинэ суурьшлийн бүсэд	4926763	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	152377	548557,2

-оОо-